



БИЕЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АЛТАНХУЯГ
2020.08.03



Агуулга:



- *Эрх зүйн үндэслэл*
- *Зорилго*
- *Хэрэгжүүлсэн арга хэмжээ*
- *Үр дүн*
- *Санал хүсэлт*
- *Цаашид анхаарах асуудал*



Эрх зүйн үндэслэл



- ◆ Монгол улсын Засгийн газрын 2011 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 32 дугаар тогтоол
- ◆ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/
- ◆ Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2016-2019 оны үндсэн чиглэл
- ◆ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 10-р сарын 18-ны өдрийн 112 дугаар тогтоол



Зорилго:



- ◆ Нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг дэмжиж, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдэд шуурхай, соёлтой үйлчлэх
- ◆ Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагын зохистой түншлэл, салбар хоорондын уялдаа холбоо, төлөвлөлтийг сайжруулах
- ◆ Биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх
- ◆ Тамирчдын спортын амжилтыг олон улсын түвшинд хүргэх, залгамж халааг бэлтгэх



БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



- Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2 дахь үе шатны төлөвлөгөөг 3 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- НБТ-ын чиглэлээр 8 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 100 % - 8 биелэлт 100 %
- Их спортын чиглэлээр 8 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 70 % - 1
 - 100 % - 7 биелэлт 96.2 %
- Олимпийн танхим, материаллаг баазыг бэхжүүлэх 2 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 70 % - 1
 - 100 % - 1 биелэлт 85 %-тай хэрэгжиж байна.
- 3 зорилт 18 арга хэмжээний биелэлт
 - 100 % - 16
 - 70 % - 2 биелэлт 96.66 % (4.83)-тэй байна.



БИЕЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Биеийн тамир, спорт чийрэгжүүлэлтийг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, чанар хүртээмжийг сайжруулан, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх

- Нийтийн биеийн тамир их спортын чиглэлээр 1118 арга хэмжээнд 208.702 хүн хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн өдөр ба нарны алхалтыг Аймгийн Засаг даргын 2017 оны А/217 тоот захирамжаар бүх сумдад зохион явуулж 30017 хүнийг хамруулж, төрийн албан хаагчдын спортын анхдугаар наадам, иргэдийн спортын наадам, Төв түмний цэнгэл наадам, Үндэсний спортын VI их наадам, Хүүхдийн спортын VI их зохион байгуулан явуулсан.






БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ




НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР ИХ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

■ НБТ- арга хэмжээний тоо ■ Хамрагдсан хүний тоо ■ эзлэх хувь



Аймгийн аварга шалгаруулах тэмцээн

■ ААШТ-ний төрөл
■ Арга хэмжээний тоо
■ Хамрагдсан хүний тоо






БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



- Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн судалгаанд 172333 хүн хамруулж, 60314 хүн буюу 34.9 хувь нь зохих түвшинд хүрч, судалгааны дүнгээр сурагчдын 32.3 % нь зохих түвшинд хүрэхгүй, 13,8 % нь бага жинтэй, 19,6 % нь илүүдэл жинтэй, 62.9 % нь илүүдэд жинтэй цүнх үүрч, 44.7 % нь амьсгалын тогтолцооны өвчтэй байна гэсэн дүгнэлт гарсан.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



- Спортын 23 холбоотой хамтран ажиллаж улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдийг зохион явуулж Цана, чөлөөт бөх, бокс, жү-до, сагсан бөмбөг, үндэсний сур, үндэсний бөх, шагайн харваа, хөл бөмбөг, ширээний теннис, дугуйн холбоодод 59,7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Цана /өсвөр үе, насанд хүрэгчид/ дугуй /өсвөр үе/, чөлөөт бөх /залуучууд/, хөнгөн атлетик /өсвөр үе/, пауэрлифтинг /өсвөр үе/, софт теннис /өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид/, үндэсний сур /залуучууд/, хөл бөмбөг /залуучууд/-ийн улсын аварга шалгаруулах тэмцээн, тал нутгийн марафон, масристинг, бокс, богд хан уулын марафон зэрэг олон улсын тэмцээнүүдийг зохион байгуулан явуулсан.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Төв цэнгэлдэх хүрээлэнд хөл бөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, волейбол, гүйлт алхалт, дугуйн 500 м-ийн асфалтан зам, шагайн харвааны асар, үндэсний сурын талбайг 636.219.075 төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулж ашиглалтанд оруулж Хүмүүн цогцолбор сургууль, Алтанбулаг, Аргалант, Баянхангай, Эрдэнэсант, Угтаалцайдам сумд биеийн тамирын гадаа талбайгаа шинэчлэн тохижуулсан.



Гүйлт, алхалт, дугуйн зам



Софт теннисний талбай



Сагсан бөмбөгийн талбай



Волейболын талбай



Шагайн харвааны асар



Үндэсний сурын талбай



БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Олон улсын хөл бөмбөгийн холбооны дэмжлэгээр 850.000 долларын хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн олон улсын стандартын талбай, Баянцогт, Эрдэнэсант, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Алтанбулаг сумдад соёл, спортын төв, Цээл, Эрдэнэ сумдад ЕБС-ийн спорт заал, Баянхангай, Аргалант, Лүн суманд спорт заал ашиглалтанд орсон. .





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ




Их спортыг хөгжүүлэн, спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэнэ

- Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд-29, Насанд хүрэгчид-17, Ахмад-8, Үндэсний спортын-16, нийт давхардсан тоогоор 371 арга хэмжээнд 71116 хүн хамрагдсан. Тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 24 төрлөөр 781 тамирчин оролцож алт 484, мөнгө 560, хүрэл 663, нийт 1707 медаль хүртэж олон улсын хэмжээний мастер 4, спортын мастер 19, спортын дэд мастер 20, зэрэгтэй тамирчин 2207, шүүгч 4 шинээр төрөн гарсан.

Аймгийн аварга шалгаруулах тэмцээн



Олон улс, УАШТ-нээс авсан медаль





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Өсвөр үеийн шигшээ багийг спортын 13 төрлөөр 160 тамирчинтай бэлтгэл-сургалт, дасгалжуулалтыг явуулж, тив, дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн болон нэрэмжит тэмцээнээс: 2016-2019 онд 303 алт, 365 мөнгө, 422 хүрэл нийт 1090 медаль авч олон улсын хэмжээний мастер 1, спортын мастер 12, спортын дэд мастер 15 төрөн гарч, пауэрлифтингийн тамирчид 9 удаа тэшүүрийн тамирчид 4-н зай төрөлд улсын рекорд дээд амжилтыг шинэчлэн тогтоосон. Шигшээ багийн үйл ажиллагааны зардалд Засаг даргын нөөц сангаас жил бүр 20.0 сая төгрөг зарцуулан үйл ажиллагаагаа явуулж байна.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 2018 онд Зуунмод сумын 4-р сургуульд чөлөөт бөх, Жаргалант суманд цана, Заамар суманд боксын төрлүүдээр төрөлжсөн сургалттай ангид 71 сурагч сонгон шалгаруулж үйл ажиллагааг эхлүүлсэн. Эрдэнэсант суманд хөнгөн атлетик, сагсан бөмбөг, Батсүмбэр суманд волейболын анги нээх бэлтгэл ажлыг хангасан. Спортын төрөлжсөн сургалттай 640 хүүхдийн сургуулийн барилгыг барих /3 тэр бум 978.4/ 2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт улсын төсөвт тусгагдан барилга, угсралтын ажил 50 %-тай явагдаж байна.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд үндэсний спортын 16 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 27 сумын 2373 хүн хамрагдаж, үндэсний спортын VI-р их наадмын шигшээ тэмцээнд 53 тамирчин оролцож Алт-7, Мөнгө-16, Хүрэл-19, бүгд-42 медаль хүртэж, спортын мастерын болзлыг 3, спортын дэд мастерын болзлыг 3 тамирчин ханган биелүүлж, байгууллагын нэгдсэн дүнгээр II-р байр эзэлж, цом өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдав.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

- Хүүхдийн спортын наадмыг аймгийн хэмжээнд спортын 18 төрлөөр зохион явуулж 3818 хүүхдийг хамруулж улсын шигшээ тэмцээнд 23 төрлөөр 262 тамирчин оролцуулан 21 алт, 7 мөнгө, 24 хүрэл нийт 52 медаль хүртэж багийн дүнгээр улсад 3-р байр, Монголын бүх ард түмний 15-р наадмын өвлийн төрлүүдээр амжилттай оролцож 3-р байрыг эзэлсэн. Хүүхдийн спортын наадмын зохион явуулахад 14,1 сая, улсын уралдаан тэмцээнд оролцоход 15,7 сая төгрөгийг зарцуулсан.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Олимпийн танхимуудын үйл ажиллагааг сайжруулж материаллаг орчинг бүрдүүлж спортын тоног төхөөрөмжөөр хангах

- Олимпзм ба бие бялдрын хүмүүжил сэдэвт болзолт уралдааны хүрээнд олимпийн хөдөлгөөнийг сурталчлан дэлгэрүүлэх, сурагчдын олимпийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Төв нутгийн олимпийн медальтнуудын бахархал аяныг зохион байгуулж 27 сум 97 баг, 31 сургуулиудаар аялаж 20 мянган хүн хамрагдсан. Монголын үндэсний олимпийн хорооноос зохион байгуулсан аяны хүрээнд хийсэн ажлаараа улсад 1-р байр эзэлж ОХУ-ын Орлёнок зусланд 7 тамирчин 1 багш, Энэтхэг улсын Жакартад болсон Азийн спортын наадмыг үзэх эрхээр Хүмүүн сургуулийн захирал Л.Эрдэнэцэцэг шагнагдсан.





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



- Биеийн Тамир Спортын Газарт олимпын танхимыг шинэчлэн байгуулах зураг, төсвийг хийж, өрөө тасалгааг тохижуулах ажилд 5.2 сая төгрөг зарцуулан олимпийн өрөөтэй болж, жү-до, боксын сургалт дасгалжуулалтанд шаардагдах хэрэглэл материалд 20.0 сая төгрөг, чөлөөт бөхийн дэвжээ 15.0 сая, цана, тэшүүрийн хувцас хэрэглэл 14.440.0 төгрөг, шатрын танхим 8,2 сая нийт 62.280.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж хангамжийг сайжруулсан .





БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



2020 онд хийгдсэн ажлаас:

- COVID цар тахлаас шалтгаалан нийтийг хамарсан арга хэмжээг цуцалсан шийдвэрийн дагуу 392 арга хэмжээнд 54342 хүн хамруулахаас 72 арга хэмжээнд 8603 хүнийг хамруулж олон улсын 1, улсын аварга шалгаруулах 1 тэмцээнд оролцож 19 медалт хүртлээ.
- Цар тахлын үед ЕБС-ийн сурагчдын дунд спортын 9 төрлөөр цахим тэмцээнийг зохион явуулж 14 сумын 16 сургуулийн 220 хүүхдийг хамруулсан.
- Аймгийн Засаг даргын 2020 оны А/301 тоот захирамжийн дагуу нийтийн биеийн тамир, их спорт, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих аяныг зохион байгуулж байна.
- Сумдын хамтлаг, заал, гадаа талбайн ашиглалт, тоног төхөөрөмж, сумдад идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэдэг хүний судалгааг гаргах зорилгоор сумдад ажиллаж удирдамжийг Аймгийн Засаг даргаар батлуулан 27 сумын ажил байдалтай танилцсан
- Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор гадна пасдын гэрэлтүүлэг, ногон байгууламж, өрөө тасалгааг тохижуулах засвар үйлчилгээг өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэсэн.



Шинэлэг ажил





- Төрийн албан хаагчдын спортын анхдугаар их наадмыг спортын 8 төрөл /сагсан бөмбөг, волейбол, шатар, ширээний теннис, шагайн харваа, граунд гольф, аэробик, хөл бөмбөг/ зохион байгуулж 4.098 хүнийг хамруулсан.
- Иргэдийн спортын наадмыг багийн спортын төрөл /хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейбол, аялал, олон төрөлт/ зохион байгуулж 1.218 хүн хамрагдсан.
- Төв+ хөгжлийн лигийг зохион байгуулж 8 багийн 120 тамирчинг хармруулсан.
- Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор Төв түмний цэнгэл наадмыг 2017 оноос зохион байгуулсан
- Сумдаас төрсөн бахийн алдартнуудыг сурталчилах зорилгоор “манлайн баясгалант бөхийн барилдааныг жилд 4 удаа 8 сумын нэрэмжит болгон тогтмол зохион байгуулж байна.
- “Спорт форум-2019” анх удаа зохион байгуулж 13 холбоодтой уулзалт зохион байгуулсан.
- Спортын 11 төрлөөр цахим уралдааны зохион явуулж 220 хүүхдийг хамруулсан.



Шинэлэг ажил



- БТСГ-ын гадна орчны тохижилтын бүтээн байгуулалтын талаар:
- Байгууллагын орчин тойрны харуул хамгаалалтыг сайжруулах зорилгоор 8 камер шинээр байрлуулж, гадна пасад, гадна орчны гэрэлтүүлэг, спорт заалны дээврийн засвар, олимпийн өрөө, бэлтгэлийн өрөө, дугуйн өрөө, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, үүдний хэсгийн тохижилтуудыг хийхэд 16 сая төгрөгийг зарцууллаа





Хөтөлбөрийн үр дүн:



- ◆ НБТ-спортоор хичээллэх орчин сайжран хөрөнгө оруулалт нэмэгдэж 5 суманд соёл, спортын төв, 5 суманд спортын заал баригдсан.
- ◆ Төрөлжсөн сургалттай анги чөлөөт бөх, цана, боксын төрлүүдээр хичээллэж 640 хүүхдийн барилгын ажил эхэлсэн
- ◆ НБТ-их спортын санхүүжилт өмнөх оноос 26 сая төгрөгөөр нэмэгдсэн
- ◆ Зуунмод /Хүмүүн цогцолбор/, Угтаалцайдам, Мөнгөнморьт, Эрдэнэ сумын сургуулийн биеийн тамирын гадаа талбай/ засвар хийгдсэн.Баян, Баян-Өнжүүл суманд соёл амралтын хүрээлэн баригдаж байна.



Сумдаас болон спортын холбоодоос гарсан саналууд:



- ◆ Сумдад нийтийн биеийн тамирын орон тооны арга зүйчдийг томилох, цалин хөлсийг шийдвэрлэх
- ◆ Сум, сургуулийн төсөвт НБТ-ын арга хэмжээний болон улс, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардлыг тусгах
- ◆ Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг мөнгөн шагналтай болгох
- ◆ Шинээр баригдсан соёл спортын төвүүдэд спортын секц дугуйланг хичээллүүлэх тоног төхөөрөмж хэрэглэл материалаар хангах, ЕБС-тай хамтран ажиллах
- ◆ Жилийн 4 улиралд бэлтгэл хийдэг бэлтгэлийн баазтай болох /Дүнжингарав бөхийн дэвжээг түшиглэн/
- ◆ Үндэсний спортын төрлүүдийн хэрэглэл материалын хангалтыг сайжруулах, улсын уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг туслалцаа үзүүлэх



Цаашид анхаарах асуудлууд:

- ◆ Гадаа талбайн тохижилт, хэрэглэл материал тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах /БТС-ын тухай хуулийн 8.1.6 дэх заалт/
- ◆ Бүх сумдад орон тооны арга зүйчтэй болох /БТС-ын тухай хуулийн 8.1.4 дэх заалт/ цалин 160.999.500 төгрөг, үйл ажиллагааны зардал 27 сая төгрөг
- ◆ Багийн спортын төрлүүдээр өсвөрийн шигшээ баг байгуулах /БТС-ын тухай хуулийн 18.5 дэх заалт/
- ◆ Өсвөрийн шигшээ багийн зардлыг нэмэгдүүлэх /БТС-ын тухай хуулийн 8.1.3 дэх заалт/
- ◆ 640 хүүхдийн спортын сургуулийн багш, ажилчдын цалин хөлс, тоног төхөөрөмж, хэрэглэл материалд шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх /БТС-ын тухай хуулийн 7.1.1 дэх заалт/



Анхаарал хандуулсанд баярлалаа